

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
17-ны өдөр

№ 01/23

Улаанбаатар хот

сарын

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дор дурдсан нэр бүхий гишүүдийг томилсугай. Үүнд:

Ердийн гишүүд:

- 1.1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Ким Ки Хюуныг;
 - 1.2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Бэк Квангюэлыг;
 - 1.3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Хан Бэкийг;
 - 1.4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Ли Донг Вүүг;
 - 1.5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Ким Ду Хваныг;
 - 1.6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Э.Гандиймааг;
 - 1.7. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Ц.Тогоог;
 - 1.8. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Б.Анандыг;
 - 1.9. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр М.Лхамсүрэнг;
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга сонгохыг даалгасугай.
 3. Компанийг Төлөөлөн удирдах зөвлөлийг шинэчлэн сонгосонтой холбоотойгоор компанийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:



ХАН ГЮ БУН

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
17-ны өдөр

№ *02/23*

Улаанбаатар хот

сарын

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3, “Глобал Монголиа Холдингс”ХК-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэн, шийдвэрлэх болохыг дурдсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:



ХАН ГЮ БУН:

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
17-ны өдөр

№...*03/23*

Улаанбаатар хот

сарын

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 62.1.16 дахь заалт, “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекст нийцүүлэн баталж, холбогдох хууль болон Компанийн дүрэмд заасан бүрэн эрхийн хүрээнд үр ашигтай бөгөөд, батлагдсан төлөвлөгөөний дагуу удирдан явуулах тухай асуудлыг 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэн, шийдвэрлэх болохыг дурдсугай.
2. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж байгаатай холбогдуулан холбогдох өөрчлөлтийг Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төсөлд оруулж, батлах тухай асуудлыг 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсүгэй.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:



ХАНГИО БУН

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
17-ны өдөр

№. 04/23

Улаанбаатар хот
сарын

Гүйцэтгэх захирлыг шинээр томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.6 дахь хэсэг, “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулж “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн Гүйцэтгэх захирлыг шинээр томилохыг даалгасугай.
2. Компанийг Гүйцэтгэх захирлыг шинэчлэн томилсонтой холбоотойгоор компанийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:



ХАН ГЮ БУН